



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 29/08

Арвайхээр сум

Хөрөнгө балансаас, балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тарагт сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Хуучин дотуур байрны барилга 58,036,621.38 (тавин найман сая гучин зургаан мянга зургаан зуун хорин нэг) төгрөгийн балансын үнэтэй, 21,763,732.98 (хорин нэгэн сая долоон зуун жаран гурван мянга долоон зуун гучин хоёр төгрөг ерэн найман) төгрөгийн үлдэх өртөгтэй, 4,040,000 (дөрвөн сая дөчин мянга) төгрөгийн балансын үнэтэй 2020 м2 газрын хамт сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 04 сарын 24-ний өдрийн 30 дугаар тогтоолын хавсралтад заасан жагсаалтын 1 дэх хэсгийг хүчингүй болгосугай.

3.Хөрөнгийг данснаас хасах, бүртгэх ажлыг холбогдох хууль, тогтоомж журмын дагуу зохион байгуулах, хөрөнгийн хөдлөлийг Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд бүртгүүлэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ДАРГА



О.ПҮРЭВДОРЖ